



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/36

Улаанбаатар хот

Нийслэлийн өмчид 6 барилга
байгууламж бүртгэн авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 78 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 127 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул дүүрэгт улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтад орсон болон худалдан авсан нийт 7,987,188,089,00 (долоон тэрбум есөн зуун наян долоон сая нэг зуун наян найман мянга наян ес) төгрөгийн өртөг бүхий, хавсралтад дурдсан 6 барилга байгууламжийг нийслэлийн өмчид бүртгэн авсугай.

2. Нийслэлийн өмчид шинээр бүртгэж буй 6 барилга байгууламжийг санхүүгийн тайланд хөрөнгөөр бүртгэн авч, ашиглалт, хамгаалалтыг хариуцан ажиллахыг эзэмшигч байгууллагын удирдлагад үүрэг болгосугай.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (М.Мөнхбаяр)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

Нийслэлийн Засаг даргын 2024 оны
07 дугаар сарын 15 өдрийн
А/36 дугаар захирамжийн
хаваралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

Д/д	Барилга байгууламжийн нэр	Байршил	Ашиглалтад орсон он	Бүртгэх үнэ /төгрөгөөр/	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр
1	79 дүгээр цэцэрлэгийн барилга	Сонгинохайрхан дүүргийн 38 дугаар хороо, 48А байр, 1 давхар, 5 тоот	2022	506,072,000.00	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт
2	Гүний худаг /2/	Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо /Ногоон толгойн хэсэг, өлийн ам, Нарийны хэсэг, ар тарвагатайн ам /	2023	59,049,336.00	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
3	281 дүгээр цэцэрлэгийн барилга	Сүхбаатар дүүргийн 16 дугаар хороо, Бэлхийн 33-6-ийн 260 тоот	2022	2,547,066,753.00	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
4	28 дугаар цэцэрлэгийн барилга	Хан-Уул дүүргийн 3 дугаар хороо, үйлдвэрийн гудамж 47 Ж байр, 1 давхар, 5 тоот	2022	1,500,000,000.00	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт
5	324 дүгээр цэцэрлэгийн барилга	Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо, Тэнгэр рашаан гудамж, 79 Г байр	2022	790,000,000.00	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт
6	326 дугаар цэцэрлэгийн барилга	Хан-Уул дүүргийн 21 дүгээр хороо, Буянт-Ухаа 2 хороолол, өлзийтийн зам гудамж, 1053-р байр	2022	2,585,000,000.00	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт
Нийт бүртгэх барилга байгууламжийн дүн				7,987,188,089,00	